ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/05 Сайншанд

Нутгийн удирдлагын байгууллагын
төлөөлөгч сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 401 дүгээр тогтоолоор батлагдсан "Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 100 хувийн саналаар Хурлын дарга Чүлтэмийн Огтбишийг Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын Төлөөлөгчөөр сонгосугай.

2. Холбогдох хууль болон Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын дүрмийг баримтлан идэвх санаачилгатайгаар гишүүний эрх үүргээ хэрэгжүүлж ажиллахыг сонгогдсон төлөөлөгч (Ч.Огтбиш)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 7/11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013011